



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 21 өдөр

Дугаар A/09

Модот

**Сумын аварга шалгаруулах журам батлах
тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн А/13 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сумын аварга малчин” шалгаруулах журмыг нэгдүгээр хавсралтаар, “Сумын аварга саальчин” шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар, “Сумын аварга хадланч” шалгаруулах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Сумын аварга малчин”, “Сумын аварга саальчин”, “Сумын аварга хадланч” шалгаруулах журмын шалгуур үзүүлэлт хангасан малчид, саальчин, хадланчийг шалгаруулах ажлыг зохион байгуулж, сумын Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж ажиллахыг Мал үржүүлэг, технологит ажил үйлчилгээний хяналтын улсын байцаагч (Д.Өсөхгэрэл)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай сумын Засаг даргын 2020 оны А/20 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ

Сумын Засаг даргын 2026
...21...дүгээр сарын 21-ны
өдрийн А/09 дугаар 1 дүгээр
захирамжийн хавсралт

"СУМЫН АВАРГА МАЛЧИН"-ААР ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхэлж, үр ашиг бүтээмжийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг түгээн дэлгэрүүлж, залуу үедээ өвлүүлэх, малын үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах, малчдын нийгэмд оруулж байгаа хувь нэмэр, хөдөлмөрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Хэнтий аймгийн харъяат, тухайн суманд тогтвор суурьшилтай амьдарч байгаа 4 багийн малчдын сүүлийн 2 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн "Сумын аварга малчин"-аар шалгаруулна.

1.3. Багуудаас 3 хүртэлх малчныг "Сумын аварга малчин" аар шалгаруулна.

1.4. "Сумын аварга малчин"-аар шалгаруулах шийдвэрийг Хүнс, хөдөө аж ахуйн тасгийн саналыг үндэслэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

2.1. "Сумын аварга малчин"-аар тодорхойлогдож байгаа малчин дараах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

2.1.1. Мал сүргээ жилийн дөрвөн улиралд өөрөө малладаг, мал маллагааны арга туршлагаа залуу малчдад зааж сургаж, шавь малчинтай болсон байх.

2.1.2. Орон нутагт туслах малчны амьжиргааны түвшинг нэмэгдүүлж, түр болон байнгын ажлын байрыг бий болгосон байх.

2.1.3. Мал сүргийг бэлчээрийн даацад тохируулан өсгөх, сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг сэлгэн өнжөөх, отор, нүүдэл хийх зэргээр зохистой ашигладаг, доройтсон бэлчээрийг сэргээх, хортон мэрэгчтэй тэмцэх ажилд идэвхи санаачлагатай оролцдог байх.

2.1.4. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа хашаа, худагтай байх.

2.1.5. Тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлдэг, малын чанарыг сайжруулах, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх чиглэлээр сумын Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран ажилладаг байх.

2.1.6. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж болон сумын ХАА-н тасагтай гэрээ байгуулан үржлийн мал сүргээ үзлэг ангилалтад технологит хугацаанд нь тогтмол хамруулан малаа ээмэгжүүлж, бүртгэлжүүлэн мэдээллийг малын бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн байх.

2.1.7. Бог малын хээлтүүлэгчийг мал үржүүлэг, технологийн нэгжид ялган төвлөрүүлж, стандартын шаардлага хангасан, хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтад ашигладаг байх.

2.1.8. Сүрэгт эзлэх хээлтэгчийн хувийг бог малд 50, бод малд 35-аас доошгүй байлгаж, бодод шилжүүлснээр 250-аас доошгүй толгой малтай байх.

2.1.9. Таван төрлийн малын зохистой бүтцийг бүрдүүлэн нийт сүрэгт эзлэх ямааны тоог 25 хувиас хэтрүүлэхгүй байх.

2.1.10. Оны эхний 100 хээлтэгч тутмаас бод малд 90, бог малд 85 хувиар төл бойжуулсан байх.

2.1.11. Нийт мал сүргийн 20 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулсан байх.

2.1.12. Малаа оторлон тарга хүч авахуулахаас гадна өвөлжилт, хаваржилтад шаардлагатай өвс, тэжээлийг хонин толгойд шилжүүлснээр нэг малд 20 кг-аар тооцож хадлан бэлтгэсэн байх.

2.1.13. Малчин нь сүүлийн 2 жилд том малын зүй бусын хорогдол гаргаагүй байх.

2.1.14. Малчин нь ямааны ноолуурын чанарыг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулсан байх.

2.1.15. Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд малаа тогтмол хамруулж, сүүлийн 3 жилд мал сүрэгт нь малын гоц халдварт болон халдварт өвчин гараагүй байх.

2.1.16. Малчин өрхийн гишүүд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байх.

2.1.17. Малын тоо, толгойн албан татварыг тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоосон хэмжээгээр бүрэн төлсөн байх.

2.1.18. Нийгмийн хариуцлагын хүрээнд малгүй өрхийг малжуулах, орон нутгийн бүтээн байгуулалт, нийгэмд чиглэсэн арга хэмжээнд идэвхи санаачлагатай оролцож, дэмжлэг үзүүлсэн байх.

2.1.19. Улс, аймаг, сумын хэмжээнд зохион байгуулагддаг шилмэл малын үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнд тогтмол оролцдог байх.

2.1.20 Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл, 17.12 дугаар зүйл заалтыг тус тус зөрчиж хуулийн хариуцлага хүлээж байгаагүй байх

Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах зарчим

3.1. Тодорхойлогдож буй малчин доорх шаардлагыг хангасан байна.

3.1.1. Таваас доошгүй жил тогтвортой мал маллаж, амжилт гаргаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан малчин өрхийг "Сумын аварга малчин"-аар шагнуулахаар тодорхойлно.

3.1.2. Багуудаас "Сумын аварга малчин"-аар тодорхойлох малчдын материалыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, малчныг шалгаруулна.

3.1.3. Тодорхойлолт болон материалын бүрдлийг Хөдөө аж ахуйн тасаг хянаж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, баталгаажуулна.

3.2. "Сумын аварга малчин"-аар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

3.2.1. Малчны товч анкет. /Журмын 1 дугаар хавсралт/

3.2.2. Ажпын үзүүлэлт. /Журмын 2 дугаар хавсралт/

3.2.3. Багийн Засаг даргын ажил байдлын тодорхойлолт.

3.2.4. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл.

3.2.5. Оршин суугаа газрын цахим лавлагаа.

3.2.6. Эрүүл мэнд болон нийгмийн даатгалын төлөлтийн цахим лавлагаа сүүлийн 2 жилээр (гэр бүлийн гишүүд)

3.2.7. Өндөр насны тэтгэвэрт гарсан бол энэ тухай лавлагаа

3.2.8. Мал тоологын А дансны хуулбар сүүлийн 2 жилээр.

3.2.9. Үржлийн малдаа үзлэг ангилалт хийлгэсэн сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт

3.2.10. Малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн тухай цахим лавлагаа

3.2.11. Малчин малаа мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан тухай тодорхойлт

3.2.12. Малын тоо, толгойн албан татвар төлсөн тухай цахим лавлагаа.

3.2.13. Хууль хяналтын байгууллагын цахим лавлагаа.

3.2.14. Малын тоо, бүтээгдэхүүний дүнд худалдан авсан болон тавиул малын тоог оруулж тооцохгүй.


Дөрөв. Шагнал олгох

4.1. "Сумын аварга малчин"-аар шалгарсан малчдыг "Сумын аварга малчин"-ы үнэмлэх, энгэрийн тэмдэг, цом, 200,0 /Хоёр зуун мянга/-н төгрөгөөр шагнана. /Энгэрийн тэмдэгийг гэр бүлийн гишүүн /эхнэр/-т олгоно/.

4.2. Шагналыг жил бүрийн "Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн"-ээс өмнө малчны хотонд гардуулна.

“Сумын аварга малчин” шалгаруулах
журмын 1 дүгээр хавсралт

“СУМЫН АВАРГА МАЛЧИН” - ААР ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА МАЛЧНЫ АНКЕТ



..... он сар өдөр

1	Сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцгийн /эх/ нэр	
4	Өөрийн нэр	
5	Төрсөн он, сар, өдөр, нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн гишүүдийн тоо	
8	Улсад ажилласан нийт хугацаа	
9	Үүнд: Малчнаар ажилласан хугацаа	
10	Төр засгаас авсан гавъяа шагнал	

“Сумын аварга малчин” шалгаруулах
журмын 2 дугаар хавсралт

“СУМЫН АВАРГА МАЛЧИН”-ААР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА -Р БАГИЙН МАЛЧИН
..... ОВОГТОЙ -ЫН
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

20..... оны сарын-ны өдөр

№	Үзүүлэлт	Малын төрөл	Онууд	
			20... он	20.... он
Нэг: Малын төрөл, тоо				
1	Оны эхний мал /бодод шилжүүлснээр/ Оны эхний мал	Бүгд		
2	Үүнээс:	Тэмээ		
		Адуу		
		Үхэр		
		Хонь		
		Ямаа		
3	Хээлтэгч Үүнээс :	Бүгд		
		Ингэ		
		Гүү		
		Үнээ		
		Эм хонь Эм ямаа		
4	Хээлтүүлэгч Үүнээс:	Бүгд		
		Буур		
		Азарга		
		Бух		
		Хуц Ухна		
5	Бойжуулсан төл: Үүнээс:	Бүгд		
		Ботго		
		Унага		
		Тугал		
		Хурга Ишиг		
6	Зах зээлд борлуулсан мал Үүнээс:	Бүгд		
		Тэмээ		
		Адуу		
		Үхэр		
		Хонь Ямаа		
7	Үржилд худалдсан мал Үүнээс:	Бүгд		
		Тэмээ		
		Адуу		
		Үхэр		
		Хонь Ямаа		

	Үүнээс:	Тэмээ		
		Адуу		
		Үхэр		
		Хонь		
		Ямаа		
	Оны эцэст тоологдсон малын тоо	Бүгд		
11	Үүнээс:	Тэмээ		
		Адуу		
		Үхэр		
		Хонь		
		Ямаа		
		Ямаа		
	Оны эцэст бэлэн байгаа хээлтэгч	Бүгд		
12	Үүнээс:	Ингэ		
		Гүү		
		Үнээ		
		Эм хонь		
		Эм ямаа		
	Хээлтүүлэгчийн тохироо	Бүгд		
13	Үүнээс:	Буур		
		Азарга		
		Бух		
		Хуц		
		Ухна		
Хоёр: Ашиг шим ашиглалтын байдал				
	Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг, амьдын жингээр/	Бүгд		
14	Үүнээс	Тэмээ		
		Адуу		
		Үхэр		
		Хонь		
		Ямаа		
	Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	Тэмээний ноос, кг		
15		Хонины ноос, кг		
		Ямааны ноолуур, кг		
		Мах үйлдвэрлэл, кг		
		Сүү, литр		
		Бусад		
	Бүтээгдэхүүнээс олсон нийт орлого /мянган төгрөг/	Бүгд		
16	Үүнээс	Мал борлуулснаас		
		Махнаас		
		Ноос, ноолуураас		
		Сүүнээс		
		Арьс ширнээс		
		Бусад		
	Өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл, тн	Өвс		
17		Тэжээл		
		Хужир, шүү		
	Хадлангийн талбай	Талбайн хэмжээ м/2		
18		Авсан ургац, тн		
	Хашаа, худаг	Хашааны тоо		
19		Багтаамж м/3		
		Худгийн тоо		
		Хүчин чадал л/сек		
20	Хөрөнгө оруулалт	Мян.төг		
21	Татвар төлөлт	Төгрөгөөр		

Тайлбар: Дээрх үзүүлэлтийг улсын тооллого, бусад холбогдох материалуудыг үндэслэн баталгаажуулна.

..... багийнн Засаг дарга /...../

..... сумын ХААТ-ийн мэргэжилтэн /...../

Сумын Засаг даргын 2026
01 дүгээр сарын 21-ны
өдрийн А/09 дугаар
захирамжийн 2 дугаар
хавсралт

“СУМЫН АВАРГА СААЛЬЧИН” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, төллөсөн малаа саалинд бүрэн хамруулж, өрхийн үйлдвэрлэлээр хамгийн их сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байгаа саальчны хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 4 багийн малчдаас сүүлийн 2 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн “Сумын аварга саальчин”-аар шалгаруулна.

1.3 Сумын хэмжээнд 1 саальчныг шалгаруулна.

1.4. “Сумын аварга саальчин”-аар шалгаруулах ажлыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

2.1. “Сумын аварга саальчин”-аар тодорхойлогдож байгаа малчин дараах нийтлэг шаардлага шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

2.1.1. Тухайн малчны оны эхний мал нь бодод шилжүүлснээр 100-аас доошгүй байх бөгөөд 100 хээлтэгчээс бод малд 90, бог малд 85 хувиар төл бойжуулсан байх.

2.1.2. Сүрэгт эзлэх хээлтэгчийн хувь бог малд 50, бод малд 35-аас доошгүй байх.

2.1.3. Төллөсөн бүх хээлтэгчийг саалинд бүрэн хамруулж, нийт саасан сүүний хэмжээ жил дараалан өссөн байх.

2.1.4. Нэг хээлтэгчээс сааж байгаа сүү нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байх.

2.1.5. Жилийн дөрвөн улиралд сүү, цагаан идээгээ боловсруулж, зах зээлд борлуулдаг байх.

2.1.6. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж болон сумын ХАА-н тасагтай гэрээ байгуулан үржлийн мал сүргээ үзлэг ангилалтад хамруулан, ээмэгжүүлж, бүртгэлжүүлэн мэдээллийг малын бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн байх.

2.1.7. Сүү, цагаан идээ боловсруулах арга ажиллагааг залуу малчид, саальчдад зааж сургасан байх.

2.1.8. Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд малаа тогтмол хамруулж, сүүлийн 3 жилд мал сүрэгт нь малын гоц халдварт болон халдварт өвчин гараагүй байх

2.1.9. Нийт малын 20-оос доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх.

2.1.10. Малын тоо, толгойн албан татварыг тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоосон хэмжээгээр бүрэн төлсөн байх.

2.1.11. Улс, аймаг, сумаас зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнд оролцдог байх.

2.1.12. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, малын хашаа, саравч, худагтай байх.

2.1.13. Шаардлагатай хадлан, тэжээлийг жил бүр хангалттай хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн байх

2.1.14. Нийгмийн хариуцлагын хүрээнд малгүй өрхийг малжуулах, орон нутгийн бүтээн байгуулалт, нийгэмд чиглэсэн арга хэмжээнд идэвхи санаачлагатай оролцож, дэмжлэг үзүүлсэн байх.

Гурав. Тодорхойлт бүрдүүлэх, шалгаруулах зарчим

3.1. Таваас доошгүй жил тогтвортой амжилт гаргаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан 1 саальчныг “Сумын аварга саальчин”-аар тодорхойлно.

3.2. Тодорхойлолт болон материалын бүрдлийг сумын Хөдөө аж ахуйн тасаг хянаж, шаардлагатай бол газар дээр нь шалгаж, баталгаажуулна.

3.3. “Сумын аварга саальчин”-аар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

3.3.1. Саальчны товч анкет. (Хүснэгт 1-ийн дагуу)

3.3.2. Ажлын үзүүлэлт. (Хүснэгт 2-ын дагуу)

3.3.3. Багийн Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл, тогтоол.

3.3.4. Багийн Засаг даргын тодорхойлолт.

3.3.5. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл.

3.3.6. Оршин суугаа газрын цахим лавлагаа.

3.3.7. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын төлөлтийн цахим лавлагаа сүүлийн 2 жилээр /гэр бүлийн гишүүд/

3.3.8. Өндөр насны тэтгэвэрт гарсан бол энэ тухай лавлагаа

3.3.9. Мал тоологын А дансны хуулбар сүүлийн 2 жилээр.

3.3.10. Малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн тухай цахим лавлагаа

3.3.11.. Малын тоо, толгойн албан татвар төлсөн тухай лавлагаа.

3.3.12. Үржлийн малдаа үзлэг ангилалт хийлгэсэн тухай сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт.

3.3.13. Мал сүргээ мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан тухай тодорхойлолт.

3.3.14. Сумын аварга саальчинд гадны харъяалалгүй саалчныг тодорхойлохгүй

Дөрөв. Шагнал олгох

4.1. “Сумын аварга саальчин”-аар шалгарсан саальчныг “Сумын аварга саальчин”-ы үнэмлэх, энгэрийн тэмдэг, өргөмжлөл, дурсгалын цом, 200.0 (Хоёрн зуун мянга)–н төгрөгөөр шагнана.

4.2. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө малчны хотонд гардуулна.

“Сумын аварга саальчин” шалгаруулах
журмын 1 дүгээр хавсралт

“СУМЫН АВАРГА СААЛЬЧИН”-ААР ТОДОРХОЙЛОХ
ХҮНИЙ ТОВЧ АНКЕТ

..... он сар өдөр

1	Аймаг, сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцэг (эх)-ийн нэр	
4	Өөрийн нэр	
5	Төрсөн он, нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн гишүүдийн тоо	
8	Улсад ажилласан жил	
9	Үүнээс: Саальчнаар ажилласан жил	
10	Төр, засгаас авсан шагнал, огноо	

“СУМЫН АВАРГА СААЛЬЧИН”-Д ТОДОРХОЙЛОХ
..... СУМЫН СААЛЬЧИН-НЫ
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

..... он..... сар өдөр

Үзүүлэлт	Малын төрөл (доошгүй байх үзүүлэлт)	Онууд	
	 он он
Нэг. Малын төрөл, тоо			
Малын үүлдэр, омгийн нэр.			
1. Оны эхний мал бодод шилжүүлснээр			
2. Оны эхний мал			
Үүнээс:	Бүгд		
	Тэмээ		
	Адуу		
	Үхэр		
	Хонь		
3. Хээлтэгч			
Үүнээс:	Ямаа		
	Бүгд		
	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
4. Бойжуулсан төл			
Үүнээс:	Эм хонь		
	Эм ямаа		
	Бүгд		
	Ботго		
	Унага		
5. Зүй бусаар хорогдсон мал			
Үүнээс:	Тугал		
	Хурга		
	Ишиг		
	Бүгд		
	Тэмээ		
6. Орлогод авсан мал			
Үүнээс:	Адуу		
	Үхэр		
	Хонь		
	Ямаа		
	Бүгд		
7. Оны эцэст байгаа хээлтэгч			
Үүнээс:	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
8. Бэлтгэсэн тэжээл (тонн)			
	Өвс		

	Тэжээл		
	Хужир, шүү		
Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал			
9. Оны эхний нэг хээлтэгч малаас саалийн хугацаанд саасан сүү (литр)	Бүгд		
Үүнээс:	Нутгийн монгол үнээ		
	Сарлаг		
	Хайнаг		
	Ингэ		
	Гүү		
	Эм хонь		
	Эм ямаа		
10. Боловсруулсан цагаан идээ (тонн)	Бүгд		
	Сүү		
	Ааруул		
	Эзэгий		
	Аарц		
	Өрөм		
	Зөөхий		
	Айраг		
Хоормог			
11. Боловсруулсан цагаан идээнээс олсон орлого (мян. төг)	Бүгд		
	Сүү		
	Ааруул		
	Эзэгий		
	Аарц		
	Өрөм		
	Зөөхий		
	Айраг		
Хоормог			
12. Хөрөнгө оруулалт	мян.төг		
13. Татвар төлөлт	Төгрөгөөр		

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна. Саасан сүүг малын төрөл тус бүрээр тооцож гаргана.

..... багийн Засаг дарга /...../

..... сумын ХААТ-ийн мэргэжилтэн /...../

Сумын Засаг даргын...оны 01 дугаар
сарын 21-ны өдрийн 1/09 дугаар
захирамжийн ... дугаар хавсралт

СУМЫН АВАРГА ХАДЛАНЧ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хадлан бэлчээрийн талбайгаа цэвэрлэж тэгшлэх, услах, бордох, ургамлын үр нэмж тарих, хамгаалах, өнжөөх зэргээр тордож сайжруулсан амжилт гаргасан иргэний хувь нэмрийг үнэлж, урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Энэхүү журмын дагуу жил бүр 1 иргэнийг "Сумын аварга хадланч"-аар шалгаруулна.
- 1.3. "Сумын аварга хадланч"-аар шалгаруулан шагнах асуудлыг Багийн Засаг дарга нараас ирүүлсэн материалыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн тасаг хянан саналаа сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлнэ.
- 1.4. "Сумын аварга хадланчийг жил бүр шалгаруулахгүй байж болно.

Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт

2. "Сумын аварга хадланч" - аар шалгаруулах иргэн дараах шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан байна:
 - 2.1 Өөрийн эзэмшлийн хадлангийн талбайтай; техник тоног төхөөрөмжтэй, өвөлжөө, хаваржааны газартай, тус сумын харъяат. Малын А данстай, бэлчээр хадлангийн маргаангүй байх
 - 2.2 Сүүлийн 2 жил дараалан жил бүр га тутмаас хураан авсан байгалийн хадлан нь усалгаагүй талбайд 5,0 цт доошгүй байх; хадлангийн мэдээгээ тухай бүр өгсөн байх./ Жилийн эцсийн мэдээг 10-р сарын 1-нээр тасалбар болгоно./
 - 2.3 Хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор хөрсний чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, хадлангийн талбайг өнжөөж, ургамлын үр тарьсан байх, байгалийн гаралтай болон үйлдвэрийн бордоогоор бордож сайжруулдаг байх.
 - 2.4 Татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн, татварын өргүй байх.
 - 2.5. Иргэн нь өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байр бий болгох, ажиллагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан, олон нийтийг хамарсан ажилд ивэвхитэй оролцдог байх;
 - 2.6. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын төлөлтийн цахим лавлагаа сүүлийн 2 жилээр /гэр бүлийн гишүүд/
 - 2.7 Өндөр насны тэтгэвэрт гарсан бол энэ тухай лавлагаа

Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах

- 3.1. "Сумын аварга хадланч" -ийг шалгаруулан шагнах асуудлыг хөдөө аж ахуйн тасгийн саналыг үндэслэн Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 3.2.. "Сумын аварга хадланч"-чаар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлнэ:
 - 3.4. Хадланчийн товч анкет (энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу);
 - 3.5. Сүүлийн 2 жилийн ажлын үзүүлэлт (энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу);
 - 3.6. Иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 3.7. Иргэний ажил байдлын талаарх багийн Засаг даргын тодорхойлолт;
 - 3.8. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл
 - 3.9. Харилцагч татварын байгууллагын тодорхойлолт, орлогын татвар төлөлтийн баримт

Дөрөв. Шагнал олгох

- 4.1. "Сумын аварга хадланчийн үнэмлэх, дурсгалын цом, гарын бэлэг, 200,0 (хоёр зуун мянган)-н төгрөгөөр шагнана.
- 4.2. Шагналыг жил бүрийн "Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн"-ээс өмнө гардуулна.

**“СУМЫН АВАРГА ХАДЛАНЧ”-ААР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА
ИРГЭНИЙ ТОВЧ АНКЕТ**

Цээж зураг 4*6 хэмжээтэй цээж зураг

..... оны сарын өдөр

1	Сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцгийн /эх/ нэр	
4	Нэр	
5	Төрсөн он, нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн гишүүдийн тоо, тэдний эрхэлж байгаа ажил	
8	Улсад ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил	
9	Төр, засгаас авсан шагнал, огноо	

“СУМЫН АВАРГА ХАДЛАНЧ”-ДАР
ШАЛГАРУУЛАХ СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ.

Үзүүлэлт	Онууд		Тайлбар
	.. он	.. он	
1. Хадлангийн талбай /га/			
Үүнээс: -өнжөөсөн / га /			
2. Хураан авсан хадлан (тонн)			
3. Зах зээлд борлуулсан хадлан (тонн)			
4. Нэг га-гийн ургац (цн-ээр)			
Үүнээс: -усалгаатай талбайгаас (цн)			
-усалгаагүй талбайгаас (цн)			
5. Нийт борлуулалт (сая.төг)			
Үүнээс: -төлсөн татвар (сая.төг)			
-даатгалд (сая.төг/			
6. Ашиг сая. төг			
7. Ажлын байрны тоо			
8. Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн орлого (мян.төг)			

Тайлбар: Энэ хүснэгтэд зөвхөн сүүлийн 2 жилийн хадлангийн үзүүлэлтийг бичнэ. Шагнагдах үндэслэлийн талаар тодорхойлолтод дэлгэрэнгүй бичиж, холбогдох байгууллагын тодорхойлолтыг үзүүлэлт тус бүрээр бүрдүүлж ирүүлсэн байна

Үзүүлэлтийг гаргасан:

багийн Засаг дарга (.....)

Хянасан:

Мэргэжилтэн (.....)